



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 08


Мөрөн

“Шинэ Мөрөн худалдааны төв” ХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин тогтоох,  
2021 оны зардал батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 125 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Шинэ Мөрөн худалдааны төв” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлыг 17,937,400 (Арван долоон сая есөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун) төгрөгөөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн нэг сарын цалинг 130,000, нарийн бичгийн даргын цалинг 100,000 төгрөгөөр тогтоож хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан цалинг 2021 оны 01 дүгээр сараас эхлэн ажлын тайлан үр дүнг дүгнэж, тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.
3. Компанийн удирдлагын зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.


ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

113150021

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны  
өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт



“Шинэ Мөрөн Худалдааны төв”  
ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021 оны зардлын төсөв

Д/д	Зардлын төсөв	Сард	Нийт зардал
1	ТУЗ-ийн дарга, гишүүд -9	130,000	14,040,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-1	100,000	1,200,000
3	ТУЗ-ийн цалингийн зардал		15,240,000
4	НДШ		2,057,400
5	Бичиг хэргийн зардал	20,000	240,000
6	Шуудан холбоо		200,000
7	Хурлын зардал		200,000
	ДҮН		17,937,400

оОо